

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журмыг батлуулна.	Засгийн газрын тогтоол	Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/500 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэл”	Журмыг Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг үндэслэн "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, багшийн ажлын гүйцэтгэл, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ажиллаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох баримт бичгийн хамт хавсралтаар хүргүүлж	1-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг батлуулав. Хавсралт: 1 файл		
2	Олон улсын үнэлгээний тогтолцоо, систем нэвтрүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ.	Сайдын тушаал, шийдвэр	Олон улсын үнэлгээний тогтолцоо, систем нэвтрээгүй байна.	Олон улсын үнэлгээний тогтолцоо, системийн судалгаа хийнэ.	Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг олон улсын сурлагын амжилтын PISA 2025 үнэлгээний туршилтын судалгаанд хамрагдахад шаардагдах 225.8 сая төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ни й өдрийн А/114 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн. PISA 2025" циклийн туршилтын судалгааш Боловсролын үнэлгээний төв 2024.04.08-05.08-ны хооронд зохион	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					байгуулсан. Турших шалгалтад 29 сургуулийн, 28 захирал, 150 багш, 2195 сурагч хамрагдсан байна. Турших шалгалтын хүрээнд суралцагчаас үнэлгээ, асуулга болон тэдний эцэг эхээс асуулгаар судалгаа авсан. Мөн нэмэлт асуулга судалгааг сургуулийн удирдлага болон 10-р ангид байгалийн ухааны хичээл ордог багш нараас түүвэрлэн авсан. Одоогийн байдлаар даалгавар засах, кодлох, олон улсын байгууллага руу хүргүүлэх ажил хийгдэж байна. Хавсралт: 1 файл		
3	Сургуулийн өмнөх боловсролд OECD-ийн IELCWS-д хамрагдах бэлтгэл хангаж ажиллана.	Сайдын тушаал, журам	-	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарыг үнэлэх, үнэлгээний эрх зүйн орчныг бүрдүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	OECD-ийн IELCWS/ Early Learning and Child Well-being A Study/ 5 настай хүүхдүүдийн судалгаа нь улс орнуудад хүүхдийн бага насны боловсролыг сурталчлах эсвэл саад болж буй хүчин зүйлсийг илүү сайн тодорхойлоход туслах зорилгоор хүүхдийн бага насны ур чадварын харьцуулсан мэдээллээр хангадаг. 2018 онд энэхүү судалгаанд гурван улс	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					оролцсон: Англи (Их Британи), Эстони, АНУ. Судалгаанд оролцогч улс бүрийн бүртгэлтэй сургууль болон ЭЕШ-ын орчинд таван настай хүүхдүүдээс түүвэрлэн бичиг үсэг, тоо бодох чадвар, өөрийгөө зохицуулах болон нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг, мөн хүүхдийн эцэг эх, багш нараас нөхцөл байдлын болон үнэлгээний мэдээллийг цуглуулдаг судалгаа юм.		
1.2. . Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
4	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмыг боловсруулж, батлуулна.	Сайдын тушаал, журам	БСШУС-ын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”	Журмыг боловсруулж, батлуулсан байна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 18.7.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, суралцагчийн хөгжил, сурлагын амжилтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулна. 26.6.Энэ хуулийн 18.7-д заасан үнэлгээ хийх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					гишүүн батална гэсний дагуу ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨӨРИЙН БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ"-ыг шинэчлэн гэрээт ажилтан Ч.Ганцэцэг /2 сарын 06-4 сарын 06-нд ажилласан/ - тэй хамтран боловсруулж, Нийслэлийн Ерөнхий боловсролын 121 дүгээр сургууль дээр Боловсролын ерөнхий газрын мэргэжилтнүүдтэй хамтран шалгуур үзүүлэлтийг туршиж, тохирцыг шинжлэн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 15/1397 дугаар албан бичгээр журмын төсөлд Орон нутгийн БШУГ-уудаас санал авч нэгтгэн , Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс, Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын саналыг тусган журмын төслийг батлуулахаар Эйбл системд оруулав. Хавсралт: 3 файл	
--	--	--	--	--	--	--

5	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг боловсруулж батлуулна.	Сайдын тушаал, журам	Зохицуулалт байхгүй	Журмыг боловсруулж, батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ын төслийг боловсруулсан. Журмаар удирдах ажилтны ажлыг улирал тутам шалгуур үзүүлэлтийн дагуу цэцэрлэг, сургуулийн зөвлөл үнэлгээг баталгаажуулах, үнэлэх үйл ажиллагаанд оролцох боломжуудыг бий болгосон бөгөөд I, III улиралд өөрийн үнэлгээ, II, IV улиралд хөндлөнгийн үнэлгээний хэлбэрээр зохион байгуулахаар тусгасан. Үнэлгээний үр дүнг үндэслэн удирдах ажилтныг 3 түвшинд үнэлж, мэргэжил боловсролыг дээшлүүлэх, хариуцлага тооцох агуулгыг тус тус тусгасан. Журмын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолд өөрчлөлт оруулан удирдах ажилтны	2-р сар, 3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	----------------------	---------------------	---------------------------------------	--	---------------------------	--

					ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан ХНХЯ-нд хүргүүлээд байна. 5-р тогтоолын өөрчлөлтөөр энэхүү журмын нийтлэг шалгуур үзүүлэлт батлагдах учраас хүлээгдэж байгаа болно. Хавсралт: 2 файл		
6	Үндэсний болон орон нутгийн түвшинд боловсролын үнэлгээний хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна.	Чадавхжуулах сургалтын хөтөлбөр, тоо	Үнэлгээний бодлого, журам шинэчлэгдсэн.	Чадавхжуулах сургалтын хөтөлбөр, агуулгыг баталсан байна.	Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 25 дугаар тогтоол, БШУСайдын 2024 оны А/115 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын үнэлгээний төвөөс сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага, цэцэрлэг, сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улсын хэмжээнд зохион байгуулахтай холбоотойгоор нийслэл, орон нутгийн БХ, БШУГ-ын дарга-30, ахлах мэргэжилтэн-60, СӨБ-ын байгууллагын удирдах ажилтан-1173, ЕБС-ийн захирал-708, сургалтын менежер-708 давхардсан тоогоор нийт 3942 хүнд гүйцэтгэлийн үнэлгээний	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					эрх зүйн байдал, шалгуур үзүүлэлт, үнэлгээний хэлбэр, агуулга, арга хэрэгсэл, зохион байгуулалт, үнэлгээний системийн талаар сургалт зохион байгуулж үнэлгээний хүний нөөцийг чадавхжуулсан.		
7	Мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх журмыг боловсруулж батлуулна.	Сайдын тушаал, журам	Зохицуулалт байхгүй	Журмыг боловсруулж, батлуулсан байна.	Мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журмыг тухайн байгууллагын удирдах ажилтны манлайлал, багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, сургалтын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн байдал, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийттэй болон суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллыг дэмжих хамтран ажиллаж буй үйл ажиллагааны үр дүнд үндэслэн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний арга хэлбэрийг хослуулан зохион байгуулахаар төлөвлөж, журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн	3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					A/466 дугаар тогтоолоор баталсан "ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, ИТГЭЛЦҮҮР, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ" санхүүжилтийн журамтай уялдуулахаар СХОГ-ын шинжээч Адъяасүрэнтэй санал солилцож сайжруулалт хийв. Хавсралт: 1 файл		
8	Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээний журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулна.	Сайдын тушаал, журам	БШУС-ын сайдын 2020 оны А/280 дугаар тушаал	Журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	БШУСайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элссэн суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээнд 2023-2024 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн 785 ЕБС-ийн 1-р ангийн 71824 суралцагч хамрагдсан. Энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал үнэлгээний тайланд тусгагдсан ба энэхүү	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					саналын дагуу журмын төслийг шинэчлэн боловсруулан ажиллаж байна Хавсралт: 1 файл		
1.3. Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах							
9	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Сайдын тушаал, журам	БШУ-ны сайдын 2022 оны А/430 дугаар тушаал	Журмыг боловсруулж, батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам", хоёрдугаар хавсралтаар "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ыг тус тус баталсан. Энэхүү тушаалыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх албан бичгийг хүргүүлсэн боловч уг тушаалыг захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй, удирдлага зохион байгуулалтын шинжтэй захиргааны акт байх тул түүгээрээ мөрдөх талаар Хууль зүй дотоод хэргийн	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сайдны 2024.04.04-ний өдрийн 1/1592 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн болно. Хавсралт: 1 файл		
1.4. Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах							
10	Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын чанарын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Үнэлгээний удирдамж, үр дүнгийн тайлан	2023 оны тайлан	Үнэлгээ зохион байгуулахад шаардлагатай удирдамжийг боловсруулна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг 2023 онд зохион байгуулсан тул 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан. Харин шинээр Боловсролын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн 29.4.6, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/128 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж баталгаажуулах журам”-ын дагуу “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж,	5-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					баталгаажуулах үнэлгээний шалгалт”-ыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулахаар БШУ-ны сайдын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/245 дугаар тушаал батлагдсан. Хавсралт: 1 файл		
11	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон багшийн ажлын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ, хувь	Байгууллага - 90.2 Багш - 90.11	Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 25 дугаар тогтоол, БШУСайдын 2024 оны А/115 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд : 1. Төрийн болон хувийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулах товыг тогтоон Боловсролын үнэлгээний төвд хүргүүллээ. 2. "Зардал батлах тухай" БШУСайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн а/157 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг	4-р сар, 7-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					зохион байгуулахад шаардагдах зардал болох 2,172,158,696 төгрөгийг батлуулсан. 3. СӨБ-ын сургалтын байгууллага, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг улсын хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ны өдрүүдэд unelgee.eec.mn цахим системээр амжилттай зохион байгууллаа. Тус үнэлгээнд төрийн өмчийн 976, төрийн бус өмчийн 197, нийт 1173 цэцэрлэг /үүнээс: ердийн-1164, тусгай, сувилал, халамжийн-9/, 7192 багш /үүнээс: ердийн-7151, тусгай-41/ хамрагдлаа. 31 багийн комиссын 1236 хүн, 1173 үнэлгээний багийн 10557 хүн тус үнэлгээг зохион байгуулсан ба хамт олон-7192, БШУГ, БХ-ын дарга-30, мэргэжилтэн-60, удирдах ажилтан-2346 /үүнээс: эрхлэгч-1173, арга зүйч-1173/, эцэг эх, асран хамгаалагч-132902, суралцагч-132902 оролцогч талууд үнэлгээнд оролцсон байна. Хавсралт: 2 файл	
--	--	--	--	--	---	--

12	Ерөнхий боловсролын сургалтын байгууллага болон багшийн ажлын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ, хувь	Байгууллага - 74.22 Багш - 75.71	Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 25 дугаар тогтоол, БШУСайдын 2024 оны А/115 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд : 1. Төрийн болон хувийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулах товыг тогтоон Боловсролын үнэлгээний төвд хүргүүллээ. 2. "Зардал батлах тухай" БШУСайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн а/157 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад шаардагдах зардал болох 2,172,158,696 төгрөгийг батлуулсан. 3.Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улсын хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд	4-р сар, 5-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	--	----------------------------	-------------------------------------	--	--	---------------------------	--

					амжилттай зохион байгууллаа. Тус үнэлгээнд нийт 708 сургууль /үүнээс: төрийн өмчийн 691, төрийн бус өмчийн 17/, 28920 багш /үүнээс: төрийн өмчийн сургуулийн-28550, төрийн бус өмчийн сургуулийн-370, ердийн сургалттай-26195, тусгай сургалттай-272, төрөлжсөн сургалттай-2317, олон улсын хөтөлбөртэй-136/ хамрагдлаа. Үнэлгээнд БШУГ, БХ-ийн дарга-30, мэргэжилтэн-60, үнэлгээний баг-708, хамт олон-28920, сургуулийн удирдах ажилтан-2124 /үүнээс: захирал-708, сургалтын менежер-708, нийгмийн ажилтан-708/, эцэг эх, асран хамгаалагч-1080040, суралцагч-1080040 тус тус оролцсон байна. Гүйцэтгэлийн үнэлгээг Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний unelgee.eec.mn цахим системд суурилан зохион байгуулсан. Нийт 1080040 шалгалт зохион байгуулагдсанаас: бичгийн шалгалт-825807 /1-9-р анги/, онлайн шалгалт-148207 /10-12-р	
--	--	--	--	--	--	--

					анги/, бие бялдрын сорил шалгалт-106026 /биеийн тамир/ байна. Шалгалтын гүйцэтгэлийг 1-5 дугаар ангид шалгалтын дэвтрээр, 6-9 дүгээр ангид хариултын хуудсаар, 10-12 дугаар ангид онлайнаар тус тус зохион байгуулсан ба суралцагчид шалгалт дууссаны дараа шууд онлайн шалгалтын гүйцэтгэлийн анхны оноотой танилцах боломжтой байсан нь онцлог байлаа. Хавсралт: 2 файл		
13	Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах хурал зөвлөгөөн, сургалт семинар, ажил, үйлчилгээ, судалгаа боловсруулалт, ажлын хэсэгт орж ажиллана.	удирдамж, хөтөлбөр, тушаал шийдвэр	-	Батлагдсан удирдамж, хөтөлбөр, тушаал шийдвэрийн дагуу чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монголын багш нарын VIII их хурал 2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Энэхүү хурлын эхний өдөр Салбар-3. Мэргэжлийн болон техникийн боловсрол хуралдааны зохион байгуулагч, редакцын комиссоор ажиллав. 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны Их засаг танхимд эхэлсэн бөгөөд салбар хуралдааны хөтөлбөрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дагуу панел хэлэлцүүлгийн үеэр 43 төлөөлөгч цаасаар, панел хэлэлцүүлэгт 5, нэлттэй микрофонд 43 төлөөлөгч саналаа хэлсэн ба энэхүү саналыг нэгтгэсэн. 2.БШУЯ-ны ТНБД-ын А/61 дүгээр тушаалаар батлагдсан "Боловсролын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг олон нийтэд сурталчлан таниулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан. Тушаалаар томилогдсон 1-р баг Нийслэлийн Баянзүрх, Бага хангай дүүрэг, Ховд, Баян-Өлгий, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь аймагт ажилласан. 3. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/112 дугаар тушаалаар батлагдсан "Боловсрол, шинжлэх ухааны яамны "Байгууллагын соёлын төлөвлөгөө" боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр томилогдон ажиллаж, "Нийгмийн баталгаа"-ны чиглэлээр санал боловсруулах багт орж		
--	--	--	--	--	---	--	--

					ажиллаж байна. Хавсралт: 5 файл		
1.5. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах, Төрийн албан хаагчдын монгол бичгийн сургалт зохион байгуулах, гарын авлагаар хангах							
14	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үндэсний чуулган зохион байгуулна.	Чуулганаас гарах шийдвэр, зөвлөмж	-	Чуулганыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, зөвлөмж гаргаж, шийдвэр гаргагчдад танилцуулсан байна.	Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1.3, Монгол хэлний тухай хуулийн 13.1.6, Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Монгол хэл, бичгийн асуудал шийдэл 2024” үндэсний чуулганы үйл ажиллагааг Соёлын төв өргөөнд 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 500 орчим хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулав. Уг арга хэмжээг зохион байгуулахад БШУ-ны сайдын "Зардал батлах тухай" 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/16 дугаар тушаалаар 25.3 сая төгрөг зарцуулав. Үндэсний чуулганы зохион байгуулалтыг хангаж хөтөлбөрийг эцэслэн зохион	1-р сар, 2-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгуулалтыг хийж, чуулганыг зохион байгууллаа. БШУ-ны сайд Л.Энх-Амгалан "МОНГОЛ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ҮР ДҮН" сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн ба илтгэлийн РР бэлтгэв.. Чуулганаас гарсан зөвлөмжийг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон УИХ-ын БШУ-ны Байнгын хороонд хүргүүллээ. Хавсралт: 12 файл		
15	Төрийн албан хаагчдын монгол бичгийн сургалт зохион байгуулж, гарын авлагаар хангах ажлыг зохион байгуулна.	Сургалт, үйл ажиллагаа, гарын авлага	13 аймгийн 6000 орчим төрийн албан хаагчдыг оролцуулсан сургалт	Сургалт үйл ажиллагаа зохион байгуулж, ТАХ-ийг гарын авлагаар хангасан байна.	1. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас 2024 оныг Монгол Улсын Засгийн газраас "Үндэсний бичиг, соёлын жил" болгон зарласантай холбогдуулан Үндэсний бигийг түгээн дэлгэрүүлэх "Хос бичигтэн Өмнөговь" аяны нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Өмнөговь аймгийн төвийн бүх байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилт"	1-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сэдвээр мэдээлэл хийлээ. 2. Төрийн албаны зөвлөлийн албан хаагчдад "Төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага ном"-ыг 45 ш хүргүүлээ. Ажлын хэсгийн НБД А.Мөнхцэцэг монгол бичгийн сургалтыг зохион байгуулж байна. 3. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах, Төрийн албан хаагчдын монгол бичгийн сургалт зохион байгуулах, гарын авлагаар хангах ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 165 дугаар тогтоолоор "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг БШУ-ны сайдын 2020 оны А/26 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээр хэлэлцэн уг шийдвэрийг гаргуулсан ба энэхүү тогтоолд Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгээс боловсруулсан цахим "Монгол бичгийн гарын авлага"-ыг байгууллагын албан хаагч бүрд таниулах, сургалт , албан	
--	--	--	--	--	---	--

					хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, Төрийн албан хаагчийн жилийн ажлын төлөвлөгөөнд монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх зорилтыг оруулж дүгнэх талаар тусгалаа. Мөн БШУЯ-ны ТЗУГ-т монгол бичгийн чиглэлээр ажиллах, байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулахад дэмжлэг үзүүлэх, байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох ажлыг зохион байгуулж, сургалт зохион байгуулах мэргэжилтнийг авч ажиллуулж байна. Хавсралт: 2 файл		
16	Үндэсний бичгийн зөв бичих дүрмийг боловсруулж, батлуулна.	Үндэсний бичгийн зөв бичгийн дүрэм	-	Үндэсний бичгийн зөв бичгийн дүрмийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах ажлын хэсгийг байгуулсан байна.	Үндэсний бичгийн зөв бичгийн дүрэм боловсруулах ажлын хэсгийн монгол хэлний тухай хуулийн дагуу эрх бүхий судалгааны байгууллага буюу Хэл зохиолын хүрээлэн 22.2.1.монгол хэлний зөв бичих дүрэм боловсруулж, түүнд өөрчлөлт оруулах асуудлаар санал дэвшүүлэх эрхтэй байдаг	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					учраас Хэл зохиолын хүрээлэнгийн захирлын тушаалаар ажлын хэсгийг байгуулаад байна. Энэхүү ажлын хэсэгт орж ажиллах эрдэмтэн , судлаачдыг санал болгосон болно. Ажлын хэсгийн эхний хурлыг хийж ажлын төлөвлөгөө гаргасан.		
17	Монгол хэлний академик үгийн сангийн судалгааны ажлын хүрээнд веб сайт, аппликэйшн бүтээх, цахим толь бүтээнэ.	Судалгааны ажил, түүний үр дүн	Хүүхдийн академик үгийн сангийн нөөцийг тогтоор түвшинд оноох судалгааны шаардлага, шалгуур боловсруулах, СӨБ-ын болон бага боловсролын академик үгийн шинжилгээ хийгдсэн.	Судалгааны ажлыг үргэлжлүүлж веб сайт хөгжүүлэх ажлыг туршсан байна.	БШУ-ны сайдын 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн А/88 тоот, , БСҮХ-ийн захирлын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/14 тоот тушаалыг үндэслэн Ажил гүйцэтгэх гэрээ-6, худалдах, худалдан авах гэрээ-1 тус тус байгуулж, ажлыг албан ёсоор эхлүүлсэн. 1. Хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт хийх, хэлэлцүүлэх: Монгол Улсын СӨБ болон ерөнхий боловсролын бага ангид судалж буй академик үг, монгол соёлын өв үг, олон хэлний орчинд заах А түвшний үгсийг сонгож, сургалтын чиглэл, судлагдахуун, боловсролын болон хэлний түвшнээр ангилсан жагсаалтад хөндлөнгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					/Гүйцэтгэл 100%/ 2. Веб сайт, аппликейшн бүтээх чиглэлээр хөгжүүлэлтийн технологи судалж, сонголт хийсэн. Өгөгдлийн сангийн системийг MySQL технологи ашиглахаар, Веб сайтын үндсэн хэрэглэгчийн буюу админ хэсгийн хөгжүүлэлтийг Laravel технологи ашиглан бүтээхээр, Бакэнд буюу веб сервис API хөгжүүлэлтийг ажлын даалгаварт санал болгосон Node.js технологи ашиглан бүтээхээр сонгоод бүтээх ажил /50% гүйцэтгэлтэй/ явж байна. 3.Мэдээллийн сан үүсгэж, цахим толь боловсруулах: 3.1. Мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээн дараах хэвлэмэл материалуудыг цахим хэлбэрт хөрвүүлсэн. Үүнд: 1. Монгол ёс заншлын их тайлбар толь 2. Монгол ёс заншлын бага тайлбар толь 3. Монгол ёс заншлын дунд тайлбар толь 4. Монгол нүүдэлчдийн тайлбар толь III 5. Монгол нүүдэлчдийн тайлбар		
--	--	--	--	--	--	--	--

					толь I 6. Монгол нүүдэлчдийн тайлбар толь II / гүйцэтгэл 100%./ 3.2. Цахим толь боловсруулах Сургалтын төрөл бүрийн толь бичиг боловсруулан хэрэглээнд оруулахын тулд Монгол хэлээр боловсрол эзэмшиж буй (сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд) хүүхдүүдэд зориулсан соёлын өв үгс, зэрэгцээ гадаадад оршин сууж буй хүүхдүүдэд зориулан олон хэлний орчинд монгол хэл заах А, В, С түвшний үгийн жагсаалтыг гарган хэрэглээнд оруулах, ашиглах, сан бүрдүүлэхээр ажиллаж байна. 4. Цахим толийн сан бүрдүүлэх зорилгоор: Зураг дизайн гаргах, боловсруулах, сайжруулах, Аудио контент боловсруулахаар ажиллаж байна. / Гүйцэтгэл 60%./ Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын үнэлгээний чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлнэ.	Үнэлгээний онол, арга зүйн чадвараа дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдах болон бие даан суралцана.	Мэргэшүүлэх сургалтад цахим болон танхимаар хамрагдсан.	Сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна.	"Писа 2022" Монгол Улс Үндэсний тайлангийн эхийг уншиж алдааг засварлав. "Писа 2022" Үндэсний тайлангийн хүрээнд Дэлхийн банкны зөвлөхүүдийн хийсэн нэмэлт шинжилгээ, бодлого боловсруулагчдад өгөх зөвлөмж танилцуулах сургалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл	3-р сар, 6-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70%
2	Боловсролын ерөнхий хууль болон шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, мэдлэг чадвараа дээшлүүлнэ.	Хууль тогтоомжийг бие даан судлах	Хууль тогтоомжийг бие даан судалсан	Мэдлэг, чадвар дээшилсэн байна.	БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн 2024 оны А/61 дүгээр тушаалаар байгуулагдсан "Боловсролын хууль тогтоомж, холбогдох дүрэм журмыг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын хуулийн танилцуулах сургалтыг Ховд, Баян-Өлгий, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн болон Баянзүрх, Багахангай дүүргийн боловсрол, сургалтын байгууллагын 750 орчим багш, удирдах ажилтанд Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөлтэй хамтран 2024 оны 03 сараас 05 сард зохион байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн танилцуулгыг хийж, бүх хуулийн дадлага ажлыг удирдан ажиллах явцдаа эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Хавсралт: 8 файл		
3	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулж сурсан байна.	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах чадвартай болно.	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах гарын драйверыг суулгасан.	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулж сурсан байна.	Монгол бичгээр цахимаар компьютерт бичвэр боловсруулж сурсан. Байгууллагын албан хаагчдаас авах монгол бичгийн шалгалтын тестийг боловсруулж, түвшин тогтоох шалгалт авав. <i>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭᠡᠷ ᠴᠠᠬᠢᠮᠠᠭ ᠠᠷᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ</i> Хавсралт: 2 файл	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
4	Төрийн болон орон	Сургалтад	-	Төрийн болон	Төрийн болон орон нутгийн	1-р сар,	Өөрийн

	нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдах	хамрагдсан байх		орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан байна.	өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг болгох сургалтад хамрагдаж, шалгалтад хамрагдав.	2-р сар, 3-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	--	-----------------	--	---	--	------------------	---

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл /...../

Огноо: